

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 11:00 цагаас www.agm.mn цахим хэлбэрээр болж, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Энхжаргал, Бизнес хөгжил хариуцсан захирал М.Мөнхбаатар болон Үйл ажиллагаа хариуцсан захирал Ж.Наранцэцэг, ТУЗ-н дарга Б.Билэгт, Хараат бус гишүүн Б.Бүжинлхам, ТУЗ-н гишүүн Ш.Бэжид, Тооллогын комиссын дарга Х.Сарангоо, тооллогын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :

1. 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүн танилцуулах
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах
3. Ногдол ашгийн талаарх танилцуулга
4. 2025 оны санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Х.Сарангоо: Бодь даатгал ХК-н хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, 2025 оны 04 дүгээр сарын 23 Улаанбаатар хот,

Компанийн тухай хуулийн 67, 69.1, 69.2 болон “Бодь Даатгал” ХК-ийн компанийн дүрмийн 7.4, “Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

ТОГТООХ нь:

1. “Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд **205,333,385** ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 20 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий **228,275,458** ширхэг хувьцааны **89.95%** болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **89.95%**-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга: Х.Сарангоо, Тооллогын комиссын гишүүн: Б.Анар-Эрдэнэ, С.Дөлгөөн

Хурал эхлэхэд ирц бүрэн бүрдсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Билэгт: Хурлыг нээж үг хэлэв. / Дэлгэрэнгүй тэмдэглэлд /
Хурлын дарга А.Энхжаргал:

-Хурлын дэгийг баталснаар танилцуулав.

-Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав.

2024 онд нийт хураамжийн орлого 32,1 тэр бум төгрөг, хөрөнгө оруулалтын орлого 2,9 тэр бум, нөхөн төлбөрийн хэмжээ 11,2 тэр бум төгрөг, нийт зардал 10,5 тэр бум төгрөг, цэвэр ашиг 2,5 тэр бум төгрөгийн үйл ажиллагаатай ажиллаа. Даатгалын зах зээлийн хувьд нийт хураамжийн орлого 510

тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын орлого 40 орчим тэр бум төгрөг, нөхөн төлбөрийн хэмжээ 176,2тэр бум төгрөг, нийт зардал 168тэр бум, цэвэр ашиг 24,6тэр бум төгрөгийн салбарын үзүүлэлттэй байна. Компанийн хөрөнгийн бүтцийг харуулж байна. 2024 онд нийт хөрөнгө хөрөнгө оруулалтын орлого 56,4%, даатгалын хөрөнгө 18,6 %, үндсэн хөрөнгө 5,8%, авлага 10,1%-тай байна. Хөрөнгийн бүтцээс онцлох зүйл нь хөрөнгө оруулалт бусад хөрөнгө дотроо эзэлж байгаа хувь нь тодорхой хэмжээнд өсөж байгаа нь эерэг үр дүн харагдаж байна. Өмнөх 5 жилийн сууриар нөөц санг харуулж байна. 2020 оныг эс тооцвол тогтмол тодорхой хэмжээнд өссөн үзүүлэлттэй байна. 40,6% мэдсэн боловч төлөгдөөгүй хохирлын нөөц сан, учирч болзошгүй хохирлын нөөц сан 25,5%, учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан 25,2%, тусгай зориулалтын нөөц сан 9,1% байна.

Санхүүгийн үзүүлэлтийг харуулав.

Хөрөнгө оруулалтын орлого компанийн ашигт ажиллагаанд томоохон нөлөөллийг бий болгосон. Өмнөх жилд бил хөрөнгө оруулалтын орлогоос 1,8 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж байсан бол 2024 онд 2,9 тэрбум төгрөгийн орлоготой буюу өмнөх онтой харьцуулахад 65 хувийн өсөлттэй гарсан байна. Энэ мэтчилэн санхүүгийн үзүүлэлтийг нэгтгэн хэлэхэд татварын дараах ашиг 2,5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан.Компанийн үйл ажиллагааг дүгнэж хэлэхэд компанийн ашигт ажиллагаа татварын өмнөх байдлаар 2023 оноос 91,4 хувиар өсөж, 2,5 тэрбум төгрөгт хүрсэн. Хөрөнгө оруулалтын хувьд 2024 оны жилийн эцсийн байдлаар хадгаламж болон итгэлцлийн бүтээгдэхүүнд 88,8 хувь буюу 19,9 тэрбум төгрөгийн хөрөнгө, үнэт цаасанд 9,3 хувь буюу 2,1 тэрбум төгрөг, бусад хөрөнгө оруулалтаар 1,7 хувь буюу 0,4 тэрбум төгрөг гэх мэтчилэн хөрөнгө оруулалтуудыг үр ашигтай оновчтой байршуулснаар өгөөжийг 2,6 дахин өсгөжээ. Үйл ажиллагааны хувьд программ хангамж вэбсайтыг хөгжүүлж Odoo ERP системтэй холбосон нь шийдвэр гаргалтын оновчлолыг сайжруулах, цаг хугацаа хэмнэх зөв шийдвэр болсон. Борлуулалтын үйл ажиллагааны хувьд даатгалын үйл ажиллагаа нь 2024 оны гүйцэтгэлээр 32,1 тэрбум төгрөгийн нийт хураамжийг бүрдүүлж, үүнээс 22,1 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийг бүрдүүлж ажилласан байна. Энэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18,6 хувь гэсэн өсөлтийг үзүүлжээ. Нөхөн төлбөрийн үйл ажиллагааны ахиц дэвшил үзүүлсэн жил байлаа. Энэ дундаж нөхөн төлбөрийн хэмжээг бууруулах зорилгын хүрээнд дотоод хүчин чадалдаа тулгуурлан нөхөн төлбөрийн дуудлага хүлээн авах, авсан дуудлагын нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт хийхэд илүү анхаарч ажилласны үр дүнд жилийн эцсийн гүйцэтгэлээр нөхөн төлбөрийн нийт зардал 3,4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 23,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Жилийн эцсийн мэдэгдсэн боловч төлөгдөөгүй нөхөн төлбөр өнгөрсөн жилийн улирлын нөлөөллийг оруулан үзвэл зардал тооцсон нөхөн төлбөр 9,7 тэрбум төгрөг буюу 2023 оны жилийн эцэстэй харьцуулбал 3,9 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэйгээр 2024 оныг дуусгажээ.

А.Энхжаргал: 2-р асуудал болох ТУЗ-с гаргасан санхүүгийн үйл ажиллагааны талаарх дүгнэлтийг ТУЗ-н дэргэдэх аудитын хорооны гишүүн Ш.Бэжид танилцуулна.

Ш.Бэжид: Уншиж танилцуулав.

А.Энхжаргал: 3-р асуудал болох Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг танилцуулав.

4-р асуудлыг М.Мөнхбаатар захирал танилцуулна уу.

М.Мөнхбаатар: Бодь Даатгал компанийн хувьд 2025 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй бүсчилсэн хөгжлийн бодлого, мөн томоохон хөрөнгө оруулалт, томоохон бүтээн байгуулалттай холбоотой болон орон сууцжуулах төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулж борлуулалтын болон санхүүгийн үйл ажиллагаагаа төлөвлөлөө. Үүнтэй уялдуулаад 2025 онд андеррайтингийн менежментийг төлөвшүүлэх замаар компанийн үр ашгийг нэмэгдүүлнэ гэсэн үндсэн зорилгын хүрээнд 4 зорилтыг дэвшүүлээ.

Нэгдүгээрт хохирлын харьцааг бууруулах, хоёрдугаарт зардлын харьцааг бууруулах гэж заасан болон үүгээр дамжуулан хосолсон харьцааг зохист хэмжээнд барьж компанийн ашигт ажиллагааг дэмжинэ. Гуравдугаарт хураамжийн бус орлого буюу давхар даатгалын комиссын орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын орлогыг дахин нэмэгдүүлэх гэж заасан. Дөрөв дэх зорилтын хувьд даатгалын салбарт шинэ оролцогч талууд нэмэгдэж орж ирсэнтэй холбоотойгоор харилцагчийн халамжийн бодлогын тогтолцоог бүрдүүлэх замаар харилцагчийг тогтоон барих, урт хугацаанд хамтарч ажиллах гэсэн чиглэл, зорилтуудыг тодорхойллоо.

Санхүүгийн төлөвлөлтийн хувьд бид үр ашигт бүтцийг илүүтэйгээр бий болгоё. Хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлбэ, үр ашиггүй зардлыг бууруулъя, татвараас учирч болох эрсдэлийг илүү анхаарч ажиллахаар төлөвлөлөө.

Мэдээлэл технологийн бодлогын хувьд өнгөрсөн жил компани суурь дэд бүтэц болох вебсайт шинэчлэлийг хийж гүйцэтгэсэн. Цахим оффисыг тодорхой хэмжээнд компанийн дотоод үйл ажиллагаанд амжилттай нутагшуулсан байна. Үүн дээр тулгуурлан бид мэдээллийн технологийн аюулгүй байдлыг тодорхойлох, бэлэн байгаа дата өгөгдлийг инженерчлэн хэрэглэгч рүү чиглэсэн аппликейшн бий болгох чиглэлийг баримтлан ажиллаж байна. Цаашдаа хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлон тэдэнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг тохирсон үнээр санал болгохоор төлөвлөж байна.

Нөхөн төлбөрийн хувьд бид үйл явцыг тогтмол сайжруулах замаар дундаж нөхөн төлбөрийг бууруулах чиглэл баримтлан ажиллана. Ингээд өмнө нь хэлснээр андеррайтингийн болон эрсдэлийн үйл ажиллагааны бодлогыг тогтмол сайжруулж, стандарт гэрээ болон хураамжийг тохирсон байдлаар боловсруулахаар ажиллаж байна.

Энэ жилийн харилцагчийн халамжийн үйлчилгээний чиглэл түлхүү анхаарал хандуулан ажиллаж байна. Харилцагчийн сэтгэл ханамжийг тодорхойлох замаар даатгалын ажилтнуудын харилцааны чадварыг сайжруулах, технологи ашиглан түргэн шуурхай хариу өгөх, үүнтэй холбоотой стандартыг бий болгох, даатгуулагчдын сэтгэл ханамжийг өсгөх замаар харилцагчтай урт хугацааны харилцааг бий болгоно.

Энэ бүх үйл ажиллагааны төлөвлөлтөд тулгуурлан компанийн хувьд 2025 онд нийт хураамж 40,1 тэрбум төгрөг, цэвэр хураамж 29,1 тэрбум төгрөг, орлого тооцсон хураам 28,3 тэрбум төгрөг, даатгалын үйл ажиллагаанаасаа 17 тэрбум төгрөгийн ашигтай буюу үйл ажиллагааны зардлаа хасаад татварын дараах ашиг 5 тэрбум байхаар төлөвлөлөө. Нэгтгээд хэлбэл эрсдэлийн удирдлага болон андеррайтингийн бодлогыг бэхжүүлснээр компанийн байр суурийг тэлэх, одоо болон цаашид шинээр харилцах хэрэглэгчдийн суурь хэрэгцээг хангаж компанийн зорилт, зорилгыг хангаж ажиллана гэж үзэж байна.

А.Энхжаргал: Асуулт хариултын цаг ирсэн байна.

С.Дөлгөөн: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуухдаа системийн баруун гар талд хэсэг байгаа үүн дээр асуултаа асууж болно хуудсаа дахин рефреш хийж явуулна уу.

Асуулт 1: Энэ жилийн санхүүгийн үйл ажиллагаанд ямар хөндлөнгийн аудитын компани орсон бэ?

- Олон улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг “Гранд Торнтон” Аудитын байгууллагатай хамтарч ажилласан. 2 үе шаттай хийгдсэн. 2024 оны 8 сараас 10 /31 хүртэл завсрынх, жилийн эцсийнх 1/1-2/20 хүртэл хийгдэж дууссан. Тайлангийн аудит хийгдсэн талаарх дүгнэлтийн дэлгэрэнгүйг манай вэб сайт болон хөрөнгийн биржид байршсан тайлангаас харах боломжтой байгаа.

Асуулт 2: Ногдол ашиг хэзээ тараах вэ?

- Бид түрүүн танилцуулсан ТУЗ-н тогтоолын дагуу 4/30-ны дотор тараахаар товлогдсон байгаа.

Асуулт 3: 2024 онд үйл ажиллагааг сайжруулах ямар оновчтой ажлууд хийгдсэн бэ?

- Компани 2024 онд цахим үйлчилгээ хэрэглэгчид төвөггүй байх тал болон вэб сайтыг шинэчлэх, мөн хур дан мэдээллийн системээс мэдээлэл татаж авах, иргэд хялбар хайлтын системрүү шилжиж чадах гээд шилжсэн. Нөхөн төлбөр ямар шатанд явж байгааг харах хянах боломжтой болсон. Мөн шийдвэр гаргалтыг сайжруулах тал дээр илүү ажилласан.

Асуулт 4: Ашигт ажиллагаа өссөн харагдлаа гол хүчин зүйл юу вэ?

- Бид АЖД –н борлуулалтын сувгийг онлайн болгосон үүгээр ажиллах хүчний зардал, түрээсийн зардал буурсан, нөөц санг өсгөж хөрөнгө оруулалт өссөн, хөрөнгө оруулалтын сувгийг тэлж нэмэгдүүлсэн. Монгол банкнаас бодлогын хүүг шат дараатай бууруулсан үүнийг дагаад хүү буурсан нь сөрөг нөлөөтэй ч нөгөө талаараа хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх банк бусуудад байршуулах хэмжээгээ нэмэгдүүлсэн. ББ-д байршуулахаас гадна борлуулалтыг дэмжих гээд 2 талын давуу байсан. Нөхөн төлбөрийн зардал бас буурсан нь нөлөөлсөн.

Тооллогын комисс саналын хуудас бөглөх заавар танилцуулав.

А.Энхжаргал: Дэгийн дагуу 2024 оны ТУЗ-с гаргасан дүгнэлтийг батлах эсэх дээр санал хураалтын үйл ажиллагаа явна.

С.Дөлгөөн: Тооллогын комиссын санал өгөх заавар зааварчилгааг танилцуулав. Санал хураах үйл ажиллагаа 15 мин үргэлжилнэ.

Санал хураалт хаагдав.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо тооллогын шийдвэрийг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Бодь Даатгал” ХК-ийн саналын эрхтэй нийт **228,275,458** ширхэг хувьцаанаас **89.95%** буюу **205,333,385** ширхэг хувьцаа эзэмшиж буй **20** хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн **99.9999%** буюу **205,333,184** ширхэг хувьцаатай **19** хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **100.00%** зөвшөөрсөн, **0.00%** татгалзсан, **0.00%** түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
205,333,184	100.00%	0	0.00%	0	0.00%

А.Энхжаргал: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулъя.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу батлах,

Хурал 13:01 минутад өндөрлөн хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга :

А.Энхжаргал



Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг

